



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2023 СУУРЬ БОЛОВСРОЛ



МОНГОЛ ХЭЛ

ХУВИЛБАР А

Аймаг / дүүрэг:

Сум / сургууль:

Анги / бүлэг:

Сурагчийн овог:

Сурагчийн нэр:

Сурагчийн код:

Санамж:

- ✓ Монгол хэл, үндэсний бичиг, уран зохиолын 20 даалгаврыг 40 минутад гүйцэтгэх тул цагаа сайтар төлөвлөж бүх даалгаврыг ажиллаарай.
- ✓ Монгол хэлний даалгавруудыг гүйцэтгэхдээ эхийг уншиж, сайтар ойлгосон байхыг анхаараарай.

Их Чимэдийн багш “хүүхэд” Чимид

Зохиолч нөхдийн дунд “Мөөжиг жөөжиг алхаатай Мөнгөний хүү Чимид мөн ч хөөрхөн зохиолч шүү” гэж өхөөрдүүлэн алдаршсан Монголын хүүхдүүдэд богц богцоор нь шүлэг, дуу, ном бэлэглэсэн нэрт зохиолч М.Чимид гуай бид хоёр наяд оны үест хамт ажиллаж байлаа.

Редакцдаа бүү хэл радиодоо Чимид гуай ахмад нь. Гэлээ ч бичих, нэвтрүүлэх, гүйх харайхдаа залуусаас үл дутна. Хүүхдүүдийн дунд ажилладаг болохоор бусдаас илүү гавшгай, шуурхай, хөнгөн, сэтгэлгээ нь хүүхэд шиг. Өөрөө ч “Бие лагшин арчсан толь мэт тунгалаг, хүүхдээрээ л байна шүү дээ. Ээжийнхээ насанд хүрэх яагаа ч үгүй. Одоо дөнгөж долоон аравт хүрч яваа...” хэмээн алиална.

Чимид гуай дал хүрэх үедээ тэтгэвэртээ гарах боллоо. Сэтгүүлчид бүгд радиогийн их студид цугларч, дарга нар орж ирэн, Чимид гуайн дуунуудыг багачуул дуулж, миний зурж өгсөн элэглэл зургийг жаазлан барьж билээ. Тэр өдөр М.Чимид гуайн сэтгэл хачин их хөдөлж, муу бичгийн машин дээрээ сүүлчийн нэвтрүүлгээ нүдэндээ доголон нулимстай инээмсэглэчихсэн бичиж байлаа. Арга ч үгүй дээ, аль гучин хэдэн оноос радиотой хувь заяагаа холбосон хүн чинь. Редакц нь Чимид гуайн “Дээшээ бүр дээшээ” гээд л олон хөөрхөн дуунуудыг хангинуулж байсан сан. Чимид гуай их зохиолч Чойжилын Чимэдээс эхлээд олон хүмүүсийн багш яах аргагүй мөн.

Монголын шинэ үеийн утга зохиолын их өргөөнд С.Буяннэмэхийн дэмжлэгтэйгээр орж ирсэн М.Чимид Монголын хүүхэд залууст хэмжээгүй буян үйлдсэн хүн билээ. Тэрээр шинэ үсгийн анхны цагаан толгойг зохиолцож, олон үеийн сургуулийн хүүхдүүдийн сурах бичигт шүлэг зохиолоороо уулзсаар байсан. Зохиолчид бидний хэд хэдэн үеийнхэн Чимид гуайг мэддэг *атлаа мэддэггүй юм шиг мартагнана. Харин Мөнгөний Чимид гуайг Монголын хүүхэд залуус хэрхэн мартаж билээ. Түүний дуу, шүлгүүд сургуулийн саруул танхимд цангинасаар...

Ж.Саруулбуян “Гэгээн гэрэлт хүмүүсийн жимээр-1”

*атал- байтал

Монгол хэлний даалгаврууд

1. Эхийн гол санаа нь “**М.Чимид гуайн монголын уран зохиолд оруулсан хувь нэмэр их**” бол үүнийг илэрхийлсэн өгүүлбэр аль вэ?
 - A. Түүний дуу, шүлгүүд сургуулийн саруул танхимд цангинасаар...
 - B. М.Чимид Монголын хүүхэд залууст хэмжээгүй буян үйлдсэн хүн билээ.
 - C. Монголын шинэ үеийн утга зохиолын их өргөөнд С.Буяннэмэхийн дэмжлэгтэйгээр орж ирсэн
 - D. Зохиолчид бидний хэд хэдэн үеийнхэн Чимид гуайг мэддэг атлаа мэддэггүй юм шиг мартагнана.
2. “Бие лагшин арчсан толь мэт тунгалаг, хүүхдээрээ л байна шүү дээ. Ээжийнхээ насанд хүрэх яагаа ч үгүй. Одоо дөнгөж долоон аравт хүрч яваа...” гэсэн өгүүлбэр ямар утгыг илтгэж байна вэ?
 - A. 70 нас хүрч байгаа учраас бие барагтай, сэтгэлгээ нь өтөлсөн гэдгийг илэрхийлсэн.
 - B. Өөрийгөө залуу, ээжийгээ хөгшин гэдгийг илэрхийлсэн.
 - C. Залуухан байгаа учраас бие нь эрүүл, сэтгэлгээ нь залуу гэдгийг илэрхийлсэн.
 - D. 70 нас хүрч яваа боловч бие эрүүл, сэтгэлгээ нь залуу байгааг илэрхийлсэн.



3. “Мөөжиг жөөжиг алхаатай Мөнгөний хүү Чимид мөн ч хөөрхөн зохиолч шүү” гэсэн хэсэгт зохиогчийн ашигласан сонин содон үг хэллэг аль вэ?
- A. мөнгөний хүү
 - B. мөн ч хөөрхөн
 - C. хөөрхөн зохиолч шүү
 - D. мөөжиг жөөжиг
4. Эхэд “залуу сэтгэлгээтэй” гэсэн санааг ямар үг хэллэгээр илэрхийлсэн бэ?
- A. сэтгэлгээ нь хүүхэд шиг
 - B. бие лагшин арчсан толь мэт тунгалаг
 - C. мөөжиг жөөжиг алхаатай
 - D. гавшгай, хөнгөн шингэн
5. “М.Чимэд Монголын хүүхдүүдийг соён гэгээрүүлсэн” гэсэн санааг илтгэх өгүүлбэр аль вэ?
- A. Хүүхдүүдийн дунд ажилладаг болохоор бусдаас илүү гавшгай, шуурхай, хөнгөн, сэтгэлгээ нь хүүхэд шиг.
 - B. Чимид гуай их зохиолч Чойжилын Чимэдээс эхлээд олон хүмүүсийн багш яах аргагүй мөн.
 - C. Монголын хүүхдүүдэд богц богцоор нь шүлэг, дуу, ном бэлэглэсэн нэрт зохиолч М.Чимид.
 - D. Түүний дуу, шүлгүүд сургуулийн саруул танхимд цангинасаар...
6. “Хоёр зохиолчид М.Чимидийг дурсан ярилцлаа” гэсэн алдаатай өгүүлбэрийг зөв болгон зассан өгүүлбэр аль вэ?
- A. Хоёр зохиолчид М.Чимидийн талаар дурсан ярилцлаа.
 - B. Хоёр зохиолч М.Чимидийг дурсан ярилцлаа.
 - C. Хоёр зохиолчид зохиолч М.Чимидийг дурсан ярилцлаа.
 - D. Хоёр зохиолч М.Чимидтэй дурсан ярилцлаа.
7. “аадар + ын” гэдэгтэй адил бичих үгийг олоорой.
- A. хуйлмал
 - B. Хайдав
 - C. хайнаг
 - D. буурал
8. “М.Чимид гуай бид хоёр наяд оны үест хамт ажиллаж байлаа.” гэсэн өгүүлбэрт байгаа “наяд” гэсэн тооны нэр эхэд ямар үүргээр орсон бэ?
- A. хугацааг эрэмбэлсэн
 - B. хугацааг тоймлосон
 - C. хугацааг давтсан
 - D. хугацааг хэсэглэсэн
9. “Редакц нь Чимид гуайн “Дээшээ бүр дээшээ” гээд л олон хөөрхөн дуунуудыг хангинуулж байсан сан.” өгүүлбэрээс дуурайх үгийг олоорой.
- A. дээшээ бүр дээшээ
 - B. хангинуулж
 - C. байсан сан
 - D. хөөрхөн

10. “Сэтгүүлчид бүгд Радиогийн их студид цугларч, дарга нар орж ирэн, Чимид гуайн дуунуудыг багачуул дуулж, элэглэл зургийг жаазлан барьж билээ.” гэсэн өгүүлбэр ямар аргаар холбогдсон ЗНӨ вэ?
- A. зэрэгцүүлэн холбох үгээр холбогдсон знө
 B. зэрэгцүүлэх аялгаар холбогдсон знө
 C. зэрэгцүүлэн холбох нөхцөл, аялгаар холбогдсон знө
 D. зэрэгцүүлэн холбох нөхцөлөөр холбогдсон знө
11. “Арга ч үгүй дээ, аль гучин хэдэн оноос радиотой хувь заяагаа холбосон хүн чинь” өгүүлбэрээс зэрэгцсэн нийлмэл үгийг олоорой.
- A. хувь заяа
 B. арга ч үгүй
 C. аль гучин хэдэн он
 D. хүн чинь

Үндэсний бичгийн даалгаврууд

12. “ᠠᠮᠢᠨᠴᠢ” гадаад үгийг уншаарай.

- A. метро
 B. микро
 C. минчүү
 D. микроб

13. “аргали угалза агула-ийн эрдэни” гэсэн галигийг зөв бичсэн хэсэг аль вэ?

A.

ᠠᠷᠭᠠᠯᠢ ᠤᠭᠠᠯᠵ᠎ᠠ ᠠᠭᠤᠯᠠ
 ᠠᠶᠢᠨ ᠡᠷᠳᠡᠨᠢ

B.

ᠠᠷᠭᠠᠯᠢ ᠤᠭᠠᠯᠵ᠎ᠠ
 ᠠᠭᠤᠯᠠ ᠠᠶᠢᠨ
 ᠡᠷᠳᠡᠨᠢ

C.

ᠠᠷᠭᠠᠯᠢ ᠤᠭᠠᠯᠵ᠎ᠠ
 ᠠᠭᠤᠯᠠ ᠠᠶᠢᠨ
 ᠡᠷᠳᠡᠨᠢ

D.

ᠠᠷᠭᠠᠯᠢ ᠤᠭᠠᠯᠵ᠎ᠠ
 ᠠᠭᠤᠯᠠ ᠠᠶᠢᠨ
 ᠡᠷᠳᠡᠨᠢ

14. “ЭГЭ” гэсэн бүтэцтэй урт эгшиг орсон үгийг олоорой.

A.

ᠡᠭᠦᠭᠡ

B.

ᠡᠭᠦᠭᠡ

C.

ᠡᠭᠦᠭᠡ

D.

ᠡᠭᠦᠭᠡ

15. Хоёулаа хос эгшгээс бүтсэн үгтэй хэсгийг олоорой.

A.

ᠡᠭᠦᠭᠡ ᠡᠭᠦᠭᠡ

B.


ᠡᠭᠦᠭᠡ ᠡᠭᠦᠭᠡ

C.

ᠡᠭᠦᠭᠡ ᠡᠭᠦᠭᠡ

D.


ᠡᠭᠦᠭᠡ ᠡᠭᠦᠭᠡ

16. “ + ” холбон зөв бичсэн нь аль вэ?

В.

С.

Д.



Уран зохиолын даалгаврууд

17. Л.Түдэв “Эрээн цоохор” өгүүллэгийн “...Хожим сонсвол Шагж багш алгын чинээ цаасан дээр бүтэн ном багтаан бичиж байсан юм билээ” гэсэн хэсэгт ямар хам сэдэв илэрч байна вэ?

- А. монгол түүхийн
- В. монгол ахуй соёлын
- С. бичиг соёлын
- Д. урлаг соёлын

18. Д.Нямаа “Шөнийн талд адуу янцгаана” шүлэгтээ

“*Гүн харанхуйд тэнгэрийн заадас*

Гүүн зэл шиг сунайн цайрна” гэж дүрсэлсэн нь уран дүрслэлийн ямар арга болох вэ?

- А. амьдчилал
- В. хүншүүлэл
- С. хэтрүүлэл
- Д. адилтгал

19. Ж.К.Роулин “Харри Поттер” зохиолын “Харри тэдний шатны доорх шүүгээнд амьдарч, хүүгийнх нь багадсан хувцсыг өмсөхийн зэрэгцээ эргэн тойронд нь тохиолддог ер бусын зүйлд түүнийг буруутгаж, тайлбарыг нь үнэмшдэггүй байжээ...” гэсэн дүрслэлээс амьдралын ямар хэв маяг харагдаж байна вэ?

- А. үл тоогдон, гадуурхагдсан
- В. хүнд байдалд орсон
- С. гуньхралтай хөөрхийлөлтэй
- Д. урагшгүй бүтэлгүй

20. П.Пүрэвсүрэн “Бурханбогд аав хоёр” өгүүллэгийн “Гэлээ ч ядуухан амьдралдаа гутрах нь үгүй. Аавынхаа туранхай цээжинд наалдан дотно сайхан үнэрээр нь амьсгалан унтах юутай жаргалтай. Гэртээ ч, манааны шовгорт ч аавтайгаа байхаас сайхан юмгүй.” хэсэгт Бурханбогд хүүгийн ямар зан чанар илэрч байна вэ?

- А. хүсэл тэмүүлээр дүүрэн
- В. өөдрөг, сайхан сэтгэлтэй
- С. байгаадаа сэтгэл хангалуун
- Д. өөдрөг, эрх танхи